



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/74

Модот

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Газар эзэмших эрхээ шилжүүлэх тухай хүсэлт ирүүлсэн "Универсалтрейд" ХХК (2821702)-ийн хүсэлтийг судлан үзээд, Цэнхэрмандал сумын 1-р баг Хужхан баг, Огзом-1 136 тоот хаягт орших, 2321000713 нэгж талбарын дугаартай, худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолборын зориулалттай 9675 квадрат метр газрын эзэмших эрхийг "Хатан сэнгүр" хоршоо (4206843)-д шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Универсалтрейд" ХХК-ны эзэмшлийн 0000300888 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЗОЛЖАРГАЛ